

1 Бүртгэл

- 2024-2025 оны хичээлийн жилд Монголын Математикийн Олимпиадын Хорооноос зохион байгуулах математикийн олимпиадуудад оролцох багш, сурагчид www.mmo.mn-д бүртгүүлж өөрийн ID-тай болсон байна. Уг ID-г цаашид mmoID гэнэ.
- Дараах мэдээллийг бүртгэлийн мэдээлэл гэнэ:
 - Овог
 - Нэр
 - Регистрийн дугаар
 - И-мэйл хаяг
 - Аймаг/дүүргийн нэр
 - Сургуулийн нэр
 - Анги
 - Оролцох ангилал
 - Хүйс
 - Холбогдох утасны дугаар
- Оролцогч нь сургууль шилжихээс бусад тохиолдолд давхар mmoID-тай байж болохгүй. Суралцагч хичээлийн жилийн дундуур сургууль шилжсэн тохиолдолд очсон сургуулийнхаа бүртгэлийн ажилтанд хандан шинээр mmoID-авна. Энэ тохиолдолд улсын олимпиадын эрхээс бусад бүх эрхийг шинээр авсан mmoID бүхий бүртгэлд шилжүүлнэ. Улсын олимпиадын эрхийг шилжүүлэхгүй.
- Олимпиадад оролцогчдыг www.mmo.mn-д бүртгүүлэх ажлыг сургуулийн захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсгийн ахлагч хариуцана. Ажлын хэсгийн ахлагч өөрөө эсвэл ажлын хэсгийн өөр нэг гишүүнээр дамжуулан бүртгэлийг зохион байгуулж болно. Энэхүү бүртгэл хариуцсан хүнийг цаашид бүртгэлийн ажилтан гэнэ.
- Олимпиадад оролцогч нь өмнө нь www.mmo.mn-д бүртгүүлсэн бол mmoID-гаа, бүртгүүлээгүй бол шаардлагатай мэдээллийг бүртгэлийн ажилтанд өгнө.
- Өмнө нь mmoID-тай байсан багш сурагчид өөрсдийн мэдээллээ 2024-2025 хичээлийн жилд тохируулан шинэчлэх ба шинээр оролцох сурагчид өөрийн мэдээллийг сургуулийн бүртгэлийн ажилтанд өгч бүртгэл үүсгүүлнэ.
- Бүртгэлийн ажилтан өөрийн сургуулиас 2024-2025 оны хичээлийн жилд ММОХ-ноос зохион байгуулах аливаа олимпиадад оролцох багш, сурагчдын бүртгэлийн мэдээллийг www.mmo.mn-д оруулах, засах ажлыг гүйцэтгэнэ. (багш, сурагчдыг бүртгэлд оруулах, мэдээллийг засах, нууц үгийг шинээр үүсгэх гэх мэт).
- Бүртгэлийн ажилтан өөрийн сургуулийн бүртгэлийн мэдээллийг 2024 оны 10-р сарын 4-ны дотор өөрийн харъяа боловсролын газарт хүргүүлнэ. Мэдээлэл нь дараах хэлбэртэй байна.
 - Ажлын хэсгийн ахлагчийн овог
 - Ажлын хэсгийн ахлагчийн нэр
 - И-мэйл хаяг
 - Аймаг/дүүргийн нэр
 - Сургуулийн нэр
 - Холбогдох утасны дугаар

И-мэйл хаягаар олимпиадын сэдэв очих тул и-мэйл хаягаа ажиллаж байгаа эсэхийг сайтар нягтална уу!

- Аймаг, дүүргийн боловсролын газрууд өөрийн харъяа сургуулиудын мэдээллийг ММОХ-оос гаргасан удирдамжийн дагуу нэгтгэж 2024 оны 10-р сарын 9-ны дотор mmo61burtgel@gmail.com-оор ирүүлнэ.

10. Шинээр бүртгэл үүсгэж байгаа бүртгэлийн ажилтны нэвтрэх нэр болон нууц үгийг нэг удаад бүртгүүлсэн и-мэйл хаягаар хүргүүлнэ.
11. Бүртгэлийн ажилтнаар бүртгэгдсэн багш нарын нэрсийн жагсаалтыг 2024 оны 10-р сарын 11-нд www.mmo.mn-д нийтлэх бөгөөд үүгээр www.mmo.mn-д бүртгэлийн ажлыг явуулах эрх нээгдэнэ.
12. Бүртгэлийн ажилтан өөрийн сургуулиас оролцох багш, сурагчдыг бүртгэх, шаардлагатай тохиолдолд бүртгэлийн мэдээллийг өөрчлөх боломжтой байна. Бүртгэлийн ажлыг хэрхэн гүйцэтгэх зааврыг www.mmo.mn-д 10-р сарын 11-нд нийтлэх ба и-мэйлээр мэдэгдэнэ.
13. Бүртгэлийн ажилтан нь оролцогчдын бүртгэлийн мэдээллийг www.mmo.mn системд олимпиад эхлэхээс дор хаяж 48 цагийн өмнө оруулж, шаардлагатай тохиолдолд шинээр бүртгэл үүсгэн оролцогчдыг системд нэвтрэх, өөрийн бүртгэлийн мэдээллийг нягтлах боломжоор хангана.
14. Олимпиадад оролцогч нь өөрийн бүртгэл www.mmo.mn-д орсон эсэхийг шалгах үүрэгтэй. Бүртгэлд ороогүй тохиолдолд олимпиад эхлэхээс 24 цагийн өмнө өөрийн сургуулийн бүртгэлийн ажилтанд хандан бүртгэлд нэрээ оруулна.
15. Нууц үгээ мартсан хэрэглэгчид www.mmo.mn-ийн нэвтрэх хуудсаар дамжуулан хэдэн ч удаа шинээр нууц үг үүсгэж болно. Ингэхдээ нэвтрэх нэр юмуу бүртгэлд ашигласан имэйл хаягаа ашиглах тул өөрийн нэвтрэх нэр, имэйл хаягаа тэмдэглэж авах шаардлагатай.
16. Бүртгэлийн ажилтан өмнөх жилүүдэд олимпиадад оролцсон сурагчдыг өмнөх жилийн ID-гаар нь, өмнө нь өөр сургуулиас эсвэл өөрийн сургуулиас шинээр оролцож байгаа сурагчдад шинээр бүртгэл үүсгэнэ.
17. mmo.mn-ийн хэрэглэгчид өөрсдийн нэвтрэх эрхээ ашиглан нэвтэрч бүртгэлийн мэдээллээ өөрчлөх боломжтой. Шаардлагатай тохиолдолд mmo61burtgel@gmail.com хаягаар шаардлагатай мэдээллээ ирүүлснээр бүртгэлээ засуулж болно. Энэ тохиолдолд 20000 төгрөгийн төлбөр төлнө.
18. Аймаг, дүүргийн боловсролын газрын бүртгэлээс хоцорсон ч олимпиадад оролцох хүсэлтэй тохиолдолд эрх бүхий албан тушаалтны ажлын хэсэг томилсон тухай тогтооол, mmoID эсвэл дээр дурдсан бүртгэлийн мэдээллийг mmo61burtgel@gmail.com хаягаар ирүүлэн бүртгүүлж болно. Энэ тохиолдолд 50000 төгрөгийн төлбөр төлнө.